



МОНГОЛ УЛС
ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар A/28

Мандалговь

Г

Бичил уурхай эрхлэгчдийн
үйл ажиллагаанд хяналт,
шалгалт хийх тухай

Т

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.13, Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.1, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан, Гурван сайхан, Луус сумдын нутаг дэвсгэрт бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайчдын зохион байгуулалт, үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

С.Цэнгэлмаа (Хууль эрхзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Анхбаяр (Байгаль орчин, аялал жуучлалын газрын ахлах мэргэжилтэн)

Р.Цэрэндорж (Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч)

Хоёр. Иргэдээс ирсэн өргөдлийн дагуу сумдын бичил уурхайн зохион байгуулалт, үйл ажиллагаанд хяналт, шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, хяналт, шалгалтын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488010060